

<https://doi.org/10.69561/mjac.v25i48.3619>

Article | Fasc.4

Музейн судалгаа хөгжүүлэлтийн тойм

Сүндэвийн Энхнаран

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
ORCID: <https://orcid.org/0000-0003-1587-9583>
Холбоо барих зохиогч: bbe3mn@gmail.com

Хураангуй: XX зууны үеэс Музей судлалын олон улсын хороо (ICOFOM), Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Соёл урлаг судлалын хүрээлэн, Музей удирдах газар, Монголын үндэсний музей, их сургууль нь манай улсад музей судлалыг боломжит нөөцүүдээр ханган хөгжүүлж иржээ. Музей судлаачдын судалгааны бүтээл, ололтыг практикт тусгах, инновацжуулах, музей судлал, музейн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай болсон дүгнэлт танилцуулна.

Түлхүүр үгс: *сан хөмрөг, судалгаа, харилцаа*

Museum Research and Developments some issues

Enkhnarar Sundev

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University of
Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
ORCID: <https://orcid.org/0000-0003-1587-9583>
Corresponding author: bbe3mn@gmail.com

Abstract: Since the 20th century, the International Committee for Museum Studies (ICOFOM), the Mongolian Academy of Sciences, the Mongolian Culture and Arts Research Institute, the Musei Udirdah Gazar, the National Museum of Mongolia, and the Universities have been developing museology in our country with available resources. It will be clarified the need to reflect and innovate the research works and achievements of museologists in practice, and to improve the relations between museology and museums.

Keywords: *presevation, research, communication*

Судалгааны арга зүй

Судалгаанд холбогдох мэдээлэл цуглуулах, тайлагнах, нэгтгэн дүгнэх аргыг ашиглав.

Судалгааны үр дүн

Музей судлалыг ЮНЕСКО судалгааны музей-байгууллага бүхий зорилготой, зохион байгуулалттай мэдлэгийн салбар мөн хэмээж, эл хандлагыг Музейн олон улсын зөвлөл 1974 баталгаажуулсан билээ. Ингэж музей судлал нь өөрийн танигдах мөн чанартай, сонирхлын талбар болохоо бусдаар хүлээн зөвшөөрүүлсэн явдал нь музейн судалгааны хүрээлэн, нийгэмлэгтэй, эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл, ном зохиол, өгүүлэл бүхий музей эрхлэх онол-практикийн орчин бүрдүүлдэг судлаачдын нөр хөдөлмөрийн үр дүн гэдэгтэй хэн ч маргах аргагүй болж байна. Монголын музей судлалыг Авирмэдийн Янжив, Салли Ваттерсон, Дуламжавын Мөнхтогоо, Жамбалдоржийн Мяндал нар эдийн соёл (материал) судлал, сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, монголын түүх, ижилслийг музейд төлөөлүүлэх, тайллын чиглэлээр хийж, эрдмийн зэрэг хамгаалсан бөгөөд олон улсад хэвлүүлсэн, судлагдсан байдал бага байгаа билээ. Судалгааны объект нь Монголын үндэсний (түүхийн) музей, Богд хааны ордон музей, Хэлмэгдэгсдийн дурсгалын музей, Төрийн түүхийн музей, аймгуудын музейн сан хөмрөг цуглуулга, үзэсгэлэнгийн танхимууд байна.

Музей судлалын олон улсын хороо. Олон улсын музейн ертөнцөд музей судлалыг сан хөмрөгийн судалгаанаас ялган хөгжүүлэх, улс орнуудад музейн судалгаа шинжилгээ, онолын сэтгэлгээг хөгжүүлэх чухал ач холбогдолтой. Музей судлалын олон улсын хороо (ICOFOM)-г “Брногийн үе тэнгийнхэн”, түүн дотроо Ян Желинек тэргүүлэн санаачилж, 1977 онд үүсгэн байгуулсан. Тус хороо нь Музейн олон улсын зөвлөл (ICOM)-д хамгийн нэр хүндтэй, хамгийн олон нэр хүндтэй судлаачтай, хамгийн олон гишүүнчлэлтэй, дэлхий даяарх музейн үйл ажиллагааг чиглүүлэх онолын үндэс суурийг судлах, музейн салбарын өөрчлөлтөөс үүдсэн шинэ чиг хандлагыг бий болгох зэргээр музейд байж болох бүхий л судалгаа шинжилгээнд чиглэдэг. Музей судлалын өнгөрсөн үеэс сургамжлан, өөрийн хувь нэмрийг оруулан, мэдлэгийг аажмаар хөгжүүлэн, ирээдүйг илүү сайн болгодог шинжлэх ухааны логик, залгамжлах зарчмуудыг баримталдаг. ICOFOM-ын үндсэн үйл ажиллагаа музей судлалын судалгааны бүтээл туурвих бөгөөд жил бүр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, *ICOFOM Study Series* цуврал сэтгүүлийг, нэг сэдэвт бүтээлүүдийг тогтмол хэвлэдэг. Үүнд, *Museological Working Papers (1980 and 1981)*, *Defining the Museum of the 21st century (François Mairesse Ed, 2017)*, *Defining museums of the 21st century: plural experiences (Bruno Brulon Soares, Karen Brown, Olga Nazor Ed, 2020)*, *Des lieux pour penser: musées, théâtres, bibliothèques (Editors: Flore Garcin-Marrou, François Mairesse et Aurélie Mouton-Rezzouk ed, 2018)*, *Exposer la muséologie (Martin Schäerer, 2018)*, *Defining the Museum of the 21st Century: Evolving Multiculturalism in Museums in the United States (Yun Shun Susie Chung, Anna Leshchenko, Bruno Brulon Soares ed, 2018)*, *A History of Museology: Key authors of museological theory (Bruno Brulon Soares ed, 2018)*, *On Museology: reflections from the field (Lynn Maranda, 2021)*, Музей судлалын тулгуур ойлголт (Mairesse 2010) тэргүүтэй олон арван нэг сэдэвт бүтээлийг хэвлүүлсэн нь манай улсын музей судлаачид болон музейн сургалтад ямар нэг хэмжээгээр үр өгөөжөө өгсөөр байгаа билээ. Дэлхийн өнцөг булан бүрээс эл хороотой хамтран ажилладаг

музей судлаачдын дийлэнх нь карьерынхаа тодорхой хэсгийг музейд ажилласны дараа их сургуульд музей судлалын багшаар ажиллаж, өөрсдийн санаачилсан сургалтын хөтөлбөр, агуулгыг хэрэгжүүлсэн байдаг юм.

Шинжлэх ухааны академи. XX зууны нэгдүгээр хагаст манай улсын музей төдийгүй музей судлалын хөгжилд үүрэг хариуцлага хүлээж ажилласан. Музей судлал, музейн аргазүй, сан хөмрөгийн эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэх боломжтой “Шинжлэх ухаан, амьдрал” сэтгүүлийг 1935 оноос анхлан “Шинэ толь”, 1941 оноос “Шинжлэх ухаан”, 1957 оноос “Шинжлэх ухаан, техник”, 1960 оноос “Шинжлэх ухаан”, 1965 оноос “Шинжлэх ухаан, амьдрал” нэртэй хэвлүүлсэн байдаг. Тус сэтгүүлд музейн түүхийн талаар “Монгол ард улсын музейн ажил хөгжсөн нь” (№3, 1941) анхны өгүүлийг Н.Н.Поздняков хэвлүүлж, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, эрэн хайх, нээн илрүүлэх, хүний буруутай үйл ажиллагаа, сүйтгэл, учир явдлыг тайлбарлах утга агуулгатай түүх, танин мэдэхүйн өгүүлэл хэвлэсээр өнөөг хүрчээ. ШУА нь эртний урлагийн бүтээлийг улсын бүртгэлд авах, хадгалж хамгаалах, гадаадад гаргах, бэлэглэх, худалдаалах, зөвшөөрөл, эрх олгох тухай эрхзүйн төсөл боловсруулах, тусгай комисс бүрдүүлэх зэргээр 1921 оноос ажилласан байдаг. Жишээ нь 1921 оны 11-р сарын 19-ний 24-р хурлаар музейн салбарт хүлээх үүргээ “... музей ...байгуулахад зориулж хуучин ном судар цуглуулах, өнгөрсөн үеийн дурсгалт зүйлийг бүртгэн авах зэрэг ажил гүйцэтгэх”, Хуучны зүйлийг хамгаалах тухай дүрэм, Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхлэх үйлдвэрийн товчоо, Судар бичгийн хүрээлэнгийн тусгай хөрөнгийн дүрмээр соёлын өв, музейн тухай бодлого боловсруулах зэргээр XX зууны нэгдүгээр хагас жилд Монгол Улсын хязгаар дотор буй бүх дурсгалын зүйлийг хадгалж хамгаалах, судлах, цуглуулах, сурталчлах, зохион байгуулах, бодлого тодорхойлох чиг үүрэгтэй ажиллажээ. Мөн Ардын Засгийн газар, Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхлэх үйлдвэрийн товчоо (1924.09.05, №32)-ны Тусгай анги-д “Монгол Улсын музей байгуулж харьяат орон газрын байдал төлөв, түмэн бодис ба олны ахуй байдал бүхнийг үзүүлэн, Монгол Улсыг таньж мэдэхэд бэлтгэн хадгалбаас зохино. Улсын музейн доторх ангиуд нь 1. Түмэн бодисын анги, 2. Хуучин булш, хөшөө зэрэг археологи ба эх түүхийн анги, 3. Эд боловсруулах үйлдвэр ба хөдөө ажлын анги, 4. Этнограф хэмээх овог үндэсний төлөв ба уран сайхнаар бүтээсэн зүйлийн анги болно” хэмээн сан хөмрөгийн судалгааны чиглэлийг заажээ. Энэ нь шинжлэх ухааны сууриар музейн бүтэц, зохион байгуулалтыг шийдвэрлэсэн анхны алхам байв.

Сайд нарын зөвлөл, МАХН-ын ТХ-ноос Шинжлэх ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлыг сайжруулах (1954.09.06, №464/46)-ын тулд Орон нутаг судлах кабинетуудыг хөдөө орон нутгийн судалгааны түшиц болгох, музей байгуулах, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, бүртгэж тоолох, үзмэрт тавих ажлыг эрдэм шинжилгээний зөвлөгөө удирдамжаар ханган ажиллах, Сайд нарын зөвлөлөөс Сүхбаатар, Чойбалсан нарын хувьсгалч үйл ажиллагаа, Ардын хувьсгалын ялалт амжилтыг харуулах, музейг өргөтгөн шинэтгэх, дотоод үзмэрийг зохион байгуулах (1967.06.16) үүрэг хариуцлага хүлээлгэн ажиллуулж байв. БНМАУ-ын Соёлын яамны коллеги, Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хамтарсан хурлын “БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1971

оны 420 дугаар тогтоолыг биелүүлэх тухай” тогтоол (1980.05.09, №8/83)-оор Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, бүртгэж тоолох, үзмэрт тавих ажлыг БНМАУ-ын Соёлын яаманд хариуцуулж, судлах, эрдэм шинжилгээний зөвлөгөө удирдамжаар хангах ажлыг Шинжлэх ухааны академид хариуцуулж, комиссын бүрэлдэхүүнд Ё.Доржсүрэн, Ш.Нацагдорж, Б.Лувсанноров, Н.Цүлтэм, Н.Сэр-Оджав, С.Бадамхатан, Ж.Банзрай, Ц.Намсрай, Б.Гэрэл, Ө.Бүрнээ, С.Батчулуун нарыг томилжээ.

Музей удирдах газар. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоол (1965.10.15, №308)-оор “Төв, орон нутгийн музей кабинетуудыг одоогийн байгаа зохион байгуулалтаар байлгаж, түүнийг нэмэгдэл удирдлагаар хангах зорилгоор “...Улсын төв музейд түшиглүүлэн” Музей удирдах газрыг Соёлын яамны дэргэд байгуулжээ. Музей удирдах газар (1974.02.18, №15)-т “БНМАУ-ын эрт, шинэ үеийн түүх болон угсаатны зүйн сектор, БНМАУ-ын шинэхэн түүхийн сектор, БНМАУ-ын ерөнхий ба эдийн засаг газарзүй, геологи, палеонтологийн сектор, БНМАУ-ын ургамал, амьтан судлалын сектор, БНМАУ-ын урлаг судлал, шашингүйн суртал нэвтрүүлгийн сектор, Марксизм, Лениннизмийн секторыг байгуулж”, тус бүрийн чиглэлийн судалгааг хийжээ. Музей судлал/Studia Museologica Tomus, Fasciculus судалгааны сэтгүүлийг музей судлал, монголын судлалын тухай эрдэм шинжилгээний зүйлийг нийтлэх зорилготой, хэвлэх юмны эхийг монгол, орос, англи, франц, германаар “Улаанбаатар хотын төв музей” хүлээн авах хаягтай, 1968 онд нэгдүгээр, 1975 онд хоёрдугаар, 1977 онд гуравдугаар дэвтрийг хэвлэсэн байдаг. Нэгдүгээр дэвтэр найман өгүүлэлтэй, хоёрдугаар дэвтэр арван дөрвөн өгүүлэлтэй, Х.Нямбуу эрхэлж, хоёрдугаар дэвтрийг Нийгмийн шинжлэх ухаан, Байгалийн шинжлэх ухаан дэд хэсэгтэй Ч.Содном, Н.Довчин, гуравдугаар дэвтэр арван гурван өгүүлэлтэй Г.Сумьяа нар редакторлажээ. Эл гурван дэвтэрт музейн түүх, эдийн соёл, соёлын биет болон биет бус өвийн уламжлал түүх, арга технологийн тухай өгүүлсэн. Эрдэм шинжилгээ, арга зүйн хэлтэс Музейчдэд гарын авлага-бичмэл сэтгүүлийг 1989 онд хоёр дугаар, 1990 онд нэг дугаар хэвлэсэн. “Музейчдэд тусламж” нэгдүгээр дугаарыг Д.Алтаннавч, “Музейчдэд тусламж” хоёрдугаар дугаарыг Д.Энхтөгс, “Музейчдэд, монгол орны ургамлын нэрс” 1990 оны нэгдүгээр дугаарыг Д.Энхтөгс, Ө.Бүрнээ бэлдэж, Д.Тунгалаг редакторласан. Музейчдэд зөвлөгөө, туршлага мэдээллийг солилцох, музейн нэр томьёо, үзмэр судлал, дүрэм, заавар, сан хөмрөг, хайгуул шинжилгээ, үзүүллэг зохион байгуулалт ба үйлчилгээний тухай, Улсын төв музейн Байгалийн тасгийн эрдэм шинжилгээний ажилтан, тайлбарлагчийн бүтээлийг хэвлэсэн (Оюунхишиг 2012, 273).

Соёл, урлаг судлалын хүрээлэн. Музей судлалын хэд хэдэн судалгааны ажлыг хийсэн байдаг. Үүнд, Монгол Улсын “Музей, клубийн эдийн засгийн харилцааны зарим асуудал” (1994-1997) санал зөвлөмж; “Монголын соёлын түүх” III боть (1999)-д Музей (291-302-р талд) Ө.Бүрнээ, Д.Цэндсүрэн, Түүх, соёлын дурсгалыг хамгаалах төрийн бодлого (356-373-р талд) Ө.Бүрнээ бүлгүүд; “Соёл урлаг судлалын номзүйн бүртгэл” ном (2013)-д Музей судлал (144-159-р талд) бүлэг; “Соёл урлаг, гоо зүйн нэр томьёоны тайлбар толь” суурь судалгааны төслийн тайлан (2005-2007)-д музейн 94-н нэр томьёог Д.Цэдмаа; Соёл урлагийн тайлбар

толь: Музей III боть (2017), “Монголын соёлын үйлдвэрлэл, соёл урлагийн хувьсал өөрчлөлт” суурь судалгааны төслийн тайлан (2011-2013)-д 1.2.1. Музей (57-66 талд), 2.2. Музей (99-116-р талд) бүлгүүд болон Соёл урлагийн тайлбар толийн гуравдугаар боть: Музей (Сонинтогос, ред. 2017)-г хэвлүүлсэн. Мөн “Музей судлалын тулгуур ойлголт” ном (2014)-ыг англи хэлнээс эх хэл рүү орчуулж, тухайн үеийн Соёл иргэншлийн сургууль буюу Соёлын сургуультай хамтран “Музейн мэргэжлийн сургалт, хэрэгцээ” эрдэм шинжилгээний бага хурал (2014.05.30); СУИС-тай хамтран “Музейн маркетинг, олон нийтийн харилцаа” сертификатын сургалт (2014.06.06-08); “Эрдэнэ мэргэн бандида Агваан-Ишсамбуугийн өв” орон нутгийн музей байгуулах төсөл (2013-2015), судалгаа, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулсан. Монголын соёл урлаг судлал сэтгүүл¹ нь соёл судлал эсхүл соёл, урлагийн онол түүхийн бүлэгт музей судлал, соёлын өвийн өгүүллийг хэвлэдэг.

Монголын үндэсний музей. Улс, аймаг, орон нутгийн музейг мэргэжил эрдэм шинжилгээ-судалгааны болон - арга зүйн удирдлага, мэдээллээр 2008 оноос ханган ажиллаж байна. Музей удирдах газрын эрхлэн хэвлүүлж байсан Музей судлал эрдэм шинжилгээний сэтгүүлийг үргэлжлүүлж, С.Идшинноров (2001, IV), С.Идшинноров, Д.Цэдмаа (2003, V), А.Очир, Музейн менежмент, маркетингийн асуудал (2007, VI) дэд сэдвийн дор редакторласан байдаг. Музей судлал сэтгүүлийг Нүүдэлчдийн өв судлал² нэрээр музей судлал, эртний судлал, түүх судлал, угсаатан судлал, соёл урлаг судлал, байгаль шинжлэл хэсэгтэй 2015 он хүртэл хэвлүүлжээ. Өдгөө Музей судлал³-д музей судлалын онол, музейн түүх, цуглуулгын судалгаа, музейн үйл ажиллагаа, музей судлалын бүтээлийн эрдэм шинжилгээний шүүмж, дурсамж, Нүүдэлчдийн өв судлал⁴-д эртний судлал, антропологи, түүх, угсаатан болон урлаг судлалын тус бүр чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэж байна. Д.Бумаа, С.Буянжаргал (2018, 221) нар Музей судлал ба Нүүдэлчдийн өв судлал сэтгүүлд хэвлэгдсэн музей судлалын өгүүллийн жагсаалт (1968-2017) өгүүлэлд эх хэрэглэгдэхүүнийг 1. Музей судлалын онолын өгүүлэл, 2. Музейн түүх, түүх бичлэг, 3. Цуглуулгын судалгаа, 4. Музейн үйл ажиллагаа, 5. Эрдэм шинжилгээний тэмдэглэл, үзмэрийн эрдэм шинжилгээний тодорхойлолт, дурсамж, 6. Ном зүй гэсэн бүтцээр ялгаж, Д.Бумаагийн Музей судлал шинжлэх ухааны тухай бэсрэг өгүүллийг Музей судлалын онолын бүтцэд цөөвгөр өгүүллийн нэгдүгээрт жагсаан тус сэтгүүлүүдэд урьд өмнө музей судлалын онолын өгүүлэл хэвлэгдэж байгаагүйг тодруулсан байна.

“Музей судлал шинжлэх ухааны тухай” өгүүлэл (Бумаа 2009, 5-12) нь музей судлалын үүсэл, хөгжил, музей судлал шинжлэх ухаан болох нь хоёр хэсэгтэй,

¹ (1999, I-II), (2000, III-IV), (2003, V-VI), (2005, VII-VIII), (2010, IX-X), (2011, XII; XIII), (2013, XV; XVI), (2015, XVII; XVIII), (2016, XIX; XX), (2017, XXI; XXII; XXIII; XXIV), (2018, XXV; XXVI; XXVII; XXVIII; XXIV; XXX), (2019, XXXI; XXXII; XXXIII; XXXIV), (2020, XXXV; XXXVI; XXXVII), (2021, XL;), (2022, XLII; XLIII), (2023,).

² (2008, VIII), (2009, IX), (2010, X), (2011, XI), (2012, XII; XII), (2013, XIV; XV), (2015, XVI).

³ (2016, XVII), (2017, XVIII-I), (2018, XIX), (2019, XX), (2020, XXI), (2021, XXII), (2022, XXIII), (2023, XXIV), (2024, XXV).

⁴ (2016, XVII), (2017, XVIII-II), (2018, XIX), (2019, XX), (2020, XXI), (2021, XXII), (2022, XXIII), (2023, XXIV), (2024, XXV)

нэгдүгээр хэсэгт герман тэргүүтэй өрнөдийн орнуудад музей судлалын сэтгүүл, нэр томьёо, тайлбар толь, байгууллага байгуулагдан шинжлэх ухаан болохыг хүлээн зөвшөөрсөн. Хоёрдугаар хэсэгт ОХУ болон Смитсоны хүрээлэнгийн музей судлалын тодорхойлолтыг, мөн музей судлалын судлагдахуун, судлах зүйл, судалгааны арга, ухагдахуун, нэр томьёо, бүтэц бүрэлдэхүүнийг товчлон, Разгоны музей судлалын (MuWoP1 1982, 12), (Mench 1992, 279) ангиллыг эх хэл рүү орчуулсан байдаг.

Авирмэдийн Янжив. Монгол Улсын музейн цуглуулгын хадгалалтын зохистой орчныг бүрдүүлэх арга зам (2014) сэдвээр Соёл урлагийн их сургуульд соёл судлалын ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон. Эрдэм шинжилгээний удирдагчаар Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ч.Дашдаваа, Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ж.Цэзэн, зөвлөхөөр доктор (Ph.D), профессор С.Дулам, доктор (Ph.D), профессор Д.Бумаа нар ажиллажээ. Тус ажил нь Монгол Улсын музейн хөгжил, цуглуулгын хадгалалтын өнөөгийн байдал, Музей дэх бөс даавуу, модон үзмэрийн цуглуулгын зохистой орчныг бүрдүүлэх арга зам гэсэн үндсэн хоёр бүлэгтэй, монголын музейнүүдийн товч мэдээлэл, Улаанбаатар хотын музейнүүдийн байршлын зураг, аймгуудын музейн байршлын зураг, музейн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын талаар авсан судалгааны асуулга, материалын гэрэлтүүлэг, агаарын хэмийн зохих хэмжээ, шавж устгалд хэрэглэдэг хорнуудын жагсаалт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чөлөөтэй зорчиход шаардлагатай талбай, материалын ангилал, харилцан үйлчлэл, МҮМ-д хадгалж буй бөс даавуун хувцасны нэр төрөл, модон үзмэрийн нэр төрөл хавсралтууд, дүгнэлт (120-122), номзүй (125-127), нийт 152 хуудастай. Судалгааны ажил нь Монголын музейн сан хөмрөг дэх цуглуулгын хадгалалтын зохистой орчныг бүрдүүлэх арга замыг тодорхойлох, энэ талаар баримтлах стандарт, арга зүйн зөвлөмж боловсруулах зорилготой, консервацийн ухааны урьдчилан сэргийлэх хадгалалтын аргаар музейн сан хөмрөгийн хадгалалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, музей судлалын сан хөмрөгийг судлах судалгааны аргаар музейн сан хөмрөг дэх үзмэрийн хадгалалтын орчны өнөөгийн байдалд үнэлгээ өгсөн ба эх сурвалж судлалын арга, түүхэн зүй судлалын аргаар монголын музейн түүхэн хөгжлийг ..., бүтэц тогтолцооны, анализ синтез /индукц, дедукцийн/, статистик тоон тандалтын арга хийгээд харьцуулан жиших, ажиглалт туршилтын аргуудыг зарим үзмэрийг монголын нөхцөлд зохистой хадгалах зааврыг дэвшүүлэхэд ашигласан.

Монгол Улсын музейн хөгжил, цуглуулгын хадгалалтын өнөөгийн байдал нэгдүгээр бүлэгт музейн хөгжил, сан хөмрөг, музейн цуглуулгын хадгалалтын байдлын горим гэсэн хоёр зүйлийн судалгаандаа улсын томоохон музейн сан хөмрөгийн орчинд гэрэл гэрэлтүүлэг, дулаан чийгшил, агаарын бохирдол, хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ хийсэн. Ингэхдээ сан хөмрөгийн орчны доройтлыг мэргэжлийн боловсон хүчний дутмаг, хадгалалт хамгаалалтын зохистой орчныг бүрдүүлэхэд хөрөнгө хүч дорвитой зараагүйтэй холбож тайлбарласан. Музей дэх бөс даавуу, модон үзмэрийн цуглуулгын зохистой орчныг бүрдүүлэх арга зам хоёрдугаар бүлэгт хадгалалтад нөлөөлөх хүчин зүйлс, хадгалалтын үндсэн горим, хадгалалтын стандарт зүйлийн судалгаагаар даавуун эдлэлийн гэмтлийн

гурван шалтгаан, материалын төрлөөс хамаарсан сан хөмрөгийн зохистой орчин, сэргээн засварлалт, хадгалалтын горимуудыг санал болгосон. Ерөнхий дүгнэлтэд, монголын музейн зай талбайн хуваарилалт, сан хөмрөгийн бодлого, орчны нөлөөллийн шинжилгээ, актлах, бусдад шилжүүлэх нэр томъёоны оноолт болон музейн бусад арга зүй зөвлөмжийг тодорхойлсон. Музейн хөгжил, сан хөмрөгийн хадгалалтын өнөөгийн байдал, гэрэл гэрэлтүүлэг, бөс даавуу, модон үзмэрийн зохистой орчныг бүрдүүлэх, дулаан чийгшил, агаарын бохирдол, үнэлгээ, даавуун эдлэлийн гэмтэл, сэргээн засварлалт, хадгалалтын горимуудыг санал болгосон.

Салли Ватерсон. Жинхэнэ Монгол: Монголын музейнүүд, үндэсний өөриймслийг/ижилсэл бий болгох *Jinkhin Mongol / True Mongolian: Mongolian museums and the construction of national identity (2014)* сэдвээр философийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг Австрали улсын Деканы их сургуульд горилсон. Эрдэм шинжилгээний удирдагчаар философийн ухааны доктор (Ph.D), профессор Jonathan Sweet, философийн ухааны доктор (Ph.D) William Logan, философийн ухааны доктор (Ph.D) Andrea Witcomb нар ажиллажээ. Судалгаа хоёр бүлэг, дараалж дугаарласан долоон зүйлтэй, зургийн тайлбар, товчилсон үгсийн жагсаалт, галиг, талархал, удиртгал, VII зүйлд ерөнхий дүгнэлт (250-263), номзүй (264-306), нийт 321 хуудастай.

Эдийн соёл судлал, философийн судалгааны хүрээнд музейн утга санаа, үзэл баримтлалыг тодруулахдаа философич Н.G.Gadamer-ийн “...we must understand the whole in terms of the detail and the detail in terms of the whole...”, музей судлаач Susan Pearce-ийн “These are ascertaining the history, environment, significance and finally interpretation of the object. While the museums are not artefacts in the traditional sense, the notion of deconstructing them in a step-by-step process in order to draw the meaning of the whole is referenced here as a framework. The obvious starting point is the objects physical body, the components from which it has been constructed and any ornament which may have been added to them and so an artefact study will begin with the physical description of the piece” онолуудад суурилж, эмпирик болон герменевтик арга зүйгээр хэд хэдэн музейн дундах объект үзмэр, тайлбар, материалын уялдаа холбоог тайлах, хамтдаа түгээх, ажиглалт (12 жил)-аар үзэгч болон музейн өгүүлэмжийн хоорондын оролцоог, семиотик болон герменевтик арга зүйгээр музейгээс дамжуулж буй бодит мэдээ, хүлээн авч буй харилцан үйлчлэлийг тус бүр судалсан. Энэ ажлын эх сурвалж, баримтын судалгааг 2005, 2010, 2013 он хүртэл Улаанбаатар хотын Монголын үндэсний музей, Богд хааны ордон музей, Хэлмэгдэгсдийн дурсгалын музей, Төрийн түүхийн музейд хийж, карт, каталог, гэрэл зураг, баримт бичиг, бичмэл, гарын авлага, үзэсгэлэнгийн каталог, мультимедиа, товхимол, тайлбар, тайллын материал, үзэсгэлэнг гэрэл зураг, видео бичлэг, үгээр баримтжуулан цуглуулсан. Музейнүүдийн захирал, эрдэм шинжилгээний ажилтан, бүртгэл мэдээллийн санч, номын санч, тайлбарлагч хөтөч болон соёлын салбарт ажилладаг гадаад, дотоодын, судалгаа бүтээл нь цуглуулгатай шууд холбоотой хүмүүстэй ярилцлага судалгааг хийсэн. Монгол Улсын сүүлийн үеийн хэвлэмэл эх сурвалжууд, шинжлэх ухааны шинэ түүх, сонин хэвлэл, улс төрийн илтгэл, мэтгэлцээн зэргээр монголын түүхийг судалсан байна.

Орчин үеийн монгол хэмээх нэгдүгээр бүлгийн нэгдүгээр зүйлд Монголын түүх, танилцуулга, хоёрдугаар зүйлд Монголын музейг онолжуулах нь, гуравдугаар зүйлд 20-р зууны Монгол-социалист музей судлал; Жишээ (*case*) судалгаа хэмээх хоёрдугаар бүлгийн дөрөвдүгээр зүйлд 1990 оноос хойших музейнүүд ардчиллыг зөвшилцөж байна, тавдугаар зүйлд Хуульчлал ба Ижилсэл, зургаадугаар зүйлд Хүнд хэцүү түүх ба Жинхэнэ монгол-манж, социализм, хэлмэгдүүлэлт (*purges*), довтолгон, долоодугаар зүйлд ерөнхий дүгнэлтээ багтаан бичиглэсэн.

Салли XX зууны сүүл XXI зууны эхэн үед монголын музейд гарсан томоохон өөрчлөлтийг тодруулж тодорхойлсон. Социализмын дараа үеэс музейнүүд хэвшмэл тогтсон мета өгүүлэмж (*meta-narrative*)-ээ шинэчилж, үйл ажиллагаагаа өөрчилсөн хэдий ч үр дүн ижил төстэй байв. Ингэхдээ Монгол Улсын дотоод, гадаад улс төр, ард түмний нөлөөлөл дунд музейнүүд өвөрмөц шинэчлэн найруулсан үндэсний мастер өгүүлэмжээр хувь нэмрээ оруулсан. Музейд улс төр, олон улсын харилцааг өгүүлэх тухай, эдийн засгийн хямрал, Их Монгол Улс байгуулагдсаны ой, Чингис хааны мэндэлсэн өдрийг тойрсон соёлын дипломат үйл ажиллагаа, үндсэрхэг үзэл суртал нь музейн мета өгүүлэмжийг өөрчлөхөд хүчтэй нөлөө болов. Урадын Э.Булагийн “Чингис хааны тухайд хамааралтай улс бүр өөрсдийн утга учиртай оршихуй, уран зөгнөлт бүтэц, сценари гэж ойлгодог” хэмээснийг судалгаандаа буулгаж, Чингис хааныг монголын түүхийн гол дүр, эртний болон өнгөрсөн түүхийн уламжлалт соёлыг холбогч болгож, өнгөрсөн түүхийн бүтээгдэхүүнийг өнөө цаг хэмээн хуульчилсан хэмээсэн. Монгол Улсын хүнд хэцүү цаг үеийн түүхийн төлөөлөл, тайллыг музейд үзүүлэх, өгүүлэх, мөн монголын социалист музей судлалыг тодруулж, онолжуулсан. Нэгдүгээр зүйлд монголын түүх, зөвлөлт маягийн музейнүүд дэх түүхийн тайлал, музейн үндсийг, хоёрдугаар зүйлд олон улсын музей судлалын онолын хүрээгээр тодруулах, тохируулах, сэтгэлгээг хэрхэн хөгжүүлж байгааг авч үзэж, үндэсний онцлогтой бүтээлийн тоо олширч байгааг, нийгмийн музей судлалаар монголын музейн тухай бичсэн зүйл англи хэлээр тун бага байгааг, гуравдугаар зүйлд социализм, музей хоёр нэгдэхэд социалист музей судлал хүчтэй нөлөөлсөн болохыг, ардчиллын эхэн дэх музейн агуулгын өөрчлөлтийн тухай, улс төрийн үзэл суртлын төлөөлөгч болохыг шинжилсэн.

Дөрөвдүгээр зүйлд ардчиллаас эхлэн музейн үйл ажиллагаа явуулахаас өөр аргагүй нөхцөл байдалтай, социалист (уламжлалт) музей судлалын хэв маяг нь монголын түүхэнд нийцэж хэрхэн оршин буйг, мөн санхүүгийн хямрал, соёлын дипломат ажиллагаа, улс төр, ардын соёл зэрэг гаднын нөлөөллөөс шалтгаалж алдар суутай, дуулиан эмгэнэлтэй түүхэн үеийг музейнүүд түлхүү онцлон тэмдэглэх болсон тухайг Үндэсний, Хэлмэгдүүлэлтийн, Богд хааны ордон, Төрийн түүхийн музейн жишээгээр, тавдугаар, зургаадугаар зүйлд музейн тайллын өөрчлөлтийг өмнөх хоёр зүйлд дурдсан жишээгээр тодруулан судалж, шүүмжилсэн. Ингэхдээ тавдугаар зүйлд өнөөгийн музейд ард түмэн, улс төрийн сэтгэлгээгээр илт холбоотой байсан түүхийг эртний улсууд, Их Монгол Улс, уламжлалт соёл, ахуй гэж үечлэн тодорхойлсон. Зургаадугаар зүйлд музей дэх манжийн, социализмын, хэлмэгдүүлэлтийн (цэвэрлэгээний) үеийн мета өгүүлэмжүүд (*narrative*) бага зэрэг нэгдмэл, эсвэл салангид үлдсэн гэж судлаач мэтгэлцсэн. Музейнүүдийн өгүүлэмжийг өөрчилж, сайжруулах хүчин чармайлт гаргаж байсан хэдий боловч

гаднын нөлөөтэй их хэмжээний популист, үндсэрхэг үзэл баримтлал тусаж байна гэсэн нотолгоог гаргасан. Ардчиллын үеэс музейд санхүүгийн хямрал, үндэсний өвөрмөц байдал нөлөөлж, өөрчлөлт гарсныг ойн баяр ёслол, албан ёсны үг хэллэгээр бүрхэгдүүлсэн. Энэ хоёр хүчин зүйлийн нэгдэл нь соёлын дипломат харилцаа, дотоод руу чиглэсэн аялал жуулчлалаар дамжуулан олон нийтийн сэтгэл хөдлөлийг өдөөж, гаднын нөлөөлөл болсон. Ингэж санхүүгийн байдлаа хүчирхэг болговч нийгэм, дэлхийн нөлөөлөл нь музейн түүхийг шинэчлэн найруулж, засварлахгүй байх арга замаар нэвчсэн тул үзэл суртал сулавтар боловч оршсоор байна. Ловентал (David Lowenthal)-ын дэлхийн аялал жуулчлалд тохиолдсон “өв”-ийн тухай судалгааг монголын кейсд буулган, сэрэмжлүүлсэн.

Ерөнхий дүгнэлтэд, XVIII зууны сүүл, XIX зууны эхэн үед европ даяар тархсан музейн сүүлийн үеийн хувилбар бол Монголын музей юм. Энэхүү уламжлал нь социалист үзэл суртлаар шүүсний үр дүнд буй болсон азийн музейнүүдийн нэгэн адил бөгөөд ардчилсан нөхцөлд социалист музей зүйгээс салж, музей судлал руу шилжихийг завдаж буй болно. Монголын нөхцөл байдлыг энгийн хоёр талт үзэл баримтлал гэж нэрлэж болохгүйг нэгэнт баталсан тул социализмаас барууны музей рүү шилжиж буй хэмээж, хэргийг хялбарчлахаас үнэндээ хол явахгүй байна. Товчхондоо, Үндэсний музей социализмыг хөгжил дэвшил, тогтвортой байдлын үе гэж танилцуулан, хэлмэгдүүлэлтийг саяхныг хүртэл хүлээн зөвшөөрч байв. Үнэндээ социализмыг чөтгөр болгох гэж яарсангүй. Харин ардчилсан шинэ үеийг танилцуулснаар социализмын үеийг дарангуйлал буюу “тэр ба одоо” гэсэн хоёр хуваагдал хэмээсэн тайлбар тод томруун болсон. Энэ нь 2013 онд ардчиллын танхимд засварын ажил хийснээс хойш үзэгчид монголын нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт гарсан дэвшлийг харуулсан хуучны том танхимаас Орос, Оросын нөлөөг хүлээн зөвшөөрсөн тэмдэгтэй тулгарсан гэсэн үг юм.

Ингэж Монгол ардын хувьсгалт намыг “гэмтэтгээд” статустай болгов. Хэдийгээр ардчиллын шинэчилсэн байнгын үзэсгэлэнгийн танхим нь ардчиллыг магтан дуулж, социализмыг гутаан доромжловч өмнөх танхим нь ардчиллыг намжаасан өөр мессежийг өгсөн юм. Эсрэгээрээ Хэлмэгдэгсдийн музейд хэлмэгдүүлэлтийг чөтгөр болгодог боловч тэнцвэржүүлэх ахиц дэвшлийг харуулдаггүй. Энэ хэрэгт тус музейг албан ёсны музейн статусаас хасаж, татан буулгасан нь нөлөөлж, бас саад болсон байна. Ардчиллаас хойш хорин хоёр жил хүртэл хугацаанд Үндэсний музейн социализмын үеийн байнгын үзэсгэлэнгийн танхимуудад дотоод, гадаадын санхүүжилт олдохгүйн улмаас шинэчлэл, засвар хийсэнгүй. Чингис хааны, үндэсний онцлогийг сэргээн хөгжүүлэхийг дэмжсэн үестэй харьцуулахад социализмын үе сонирхолгүй тул XX зууныг дахин тайлбарлах нь өнөөг хүртэл гацаанд ороод байна. Хэлмэгдэгсдийн музейг төрийн хяналтаас чөлөөлсөн (хувьчилсан С.Э) нь өнөөгийн монголын онцлогт хэлмэгдүүлэлт (цэвэрлэгээ-purges)-ийн байр суурь музейд төдийлөн ач холбогдолгүй болох мессеж, далд үзэл санааг илэрхийлж байна. Хэлмэгдэгсдийн музейг албан ёсны түүхээс идэвхтэй хасаж, татан буулгасан явдлыг улстөрчдийн хэл ам, Төрийн музей байгуулагдах үетэй зэрэгцүүлэн авч үзвэл, энэ санаа тодорхой харагдана. Ардчилал эхэлснээс хойш монголын музейн үйл ажиллагаа өргөжин тэлэх боломжит алхмуудыг хийж, үр дүнд нь дотоодоос болон олон улсын агентлаг, байгууллагуудаас төслүүд хэрэгжүүлэх болсон.

Эдгээрт орчин үеийн музейн арга зүй, практикийг тайлбарлах, таниулах, үзэсгэлэн гаргах, шинжлэх ухааныг хөгжүүлэх, шинэчлэх зэргээр хэсэгчилсэн төслүүд хэрэгжсэн бөгөөд зарим тохиолдолд санхүүжилт авах хэрэгцээ шаардлагатайн дээр монголын талаарх гадаадын хоёр талын ойлголтоос үүдэлтэй юм. Музей тус бүр өөрсдийн үйл ажиллагаа, тайлбартаа монголын түүх, өргөн хүрээг хамарсан өвөрмөц байдал, шинэтгэлийг өөрчлөлттэй мөн өөрчлөлтгүйгээр тусгадаг. Музейн хананы гаднах ертөнцийн нэгэн адил, музейнүүд түүхийн агуу үе, ололт амжилтад анхаарлаа хандуулж, өнөөгийн монголчуудын бахархал болгон толилууль байна. Олон улсын соёлын дипломат ажиллагаа музейг шинэчлэн найруулах, ой тэмдэглэх, санхүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. 2000-иад оны үеэс Чингис хааны тэмдэглэлт ойнууд нь эртний төрт улс, уламжлалт соёлыг монголын түүхэнд бататгахад чухал нөлөө үзүүлсэн. Үүний эсрэгээр социализмын түүхийн үед бага анхаарал хандуулж, удаан шинэчлэгдсэн байна. Ард түмэн, улс төр, олон улсын хэмжээнд Чингис хааныг “тайлбарласан” (*unblinding*) музейнүүд уналтад орох, хоцрогдох сорилтод тулгарч байна. Үүнийг ардчиллын үеэс эхлэн ажиллаж байгаа гурван музейн (Үндэсний музей, Төрийн түүхийн музей, Хэлмэгдэгсдийн музей) судалгаа жишээгээр нэгтгэн тодруулж, монголын музейн хувьслын гүн гүнзгий, нарийн төвөгтэй дүр зураг харагдаж байна гэж дүгнэсэн.

Ингэхдээ музейн үйл ажиллагаанд нэг ч дүгнэлт гаргахгүйгээр дүн шинжилгээг хийж байгааг судалгаагаар нотоллоо гээд хэрэвзээ нэг чухал дүгнэлт хийх юм бол музейнүүд янз бүрээр хөгжсөн, хөгжих болно гэжээ. Монголын музейд Зөвлөлтийн музей судлал нөлөөлж, түлхэц болж өнөөгийн нөхцөл байдлыг хууль ёсны болгох үндэслэл суурь болж байна. Үнэндээ сүүлийн хэдэн арван жил музей мэргэжлийн өндөр стандартыг дотооддоо хадгалахыг үргэлж эрэлхийлсээр ирсэн хэдий ч гаднын хүчин их нөлөөлсөн. Монгол Улсын хувьд музей нь үндэсний онцлогийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулдаг гэж ойлгогдох боловч эдийн засгийн уналт, санхүүгийн хямрал, Их Монгол Улс байгуулагдсаны ойг тойрсон халуун сэтгэлээс үүдсэн музейн үйл ажиллагаа явуулахаас өөр аргагүйд хүрчээ. Бүс нутаг, улс төр, олон улсын хэмжээнд түүхийн тодорхой үеүд алдартай байдаг тул эдгээр музейн салбарын анхаарлыг татаж, түүхийг дахин хурдан тайлбарлахад хүргэсэн ч түүхийн бүх салбарыг мастер хүүрнэл болгон шингээж амжаагүй байгаа юм. Ардчилал өрнөсөн гуч орчим жилд монголын музей хэрхэн хөгжсөнийг эргэцүүлсэн Салли Ваттерсон ирээдүйд илүү боловсронгуй, бүрэн дүүрэн үндэсний өвөрмөц байдлын хэлэлцээрт оролцоходоо музейнүүд хэцүү эсвэл бага тайлагдсан түүхийг хэрхэн илүү сайн шийдэж чадах вэ хэмээн цаашдын асуудлыг хөнджээ.

Дуламжавын Мөнхтоого. Монголын музейн нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтыг сайжруулах судалгаа, боловсруулалт (Монголын үндэсний музейн жишээн дээр) (2019) соёл судлалын ухааны доктор (Ph.D)-ын зэргийг Соёл урлагийн их сургуульд хамгаалсан. Эрдэм шинжилгээний удирдагчаар доктор (Ph.D), профессор Ж.Долгорсүрэн, зөвлөхөөр доктор (Ph.D) Д.Батбаяр нар ажиллажээ. Судалгаа нь музейн нэхмэл эд өлгийн төрөл, онцлог, хадгалалтын өнөөгийн байдлыг судалж, түүнд тулгуурлан зохистой орчин бүрдүүлж хадгалалтыг сайжруулах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах зорилготой.

Мэдээллийн өгөгдлүүдэд задлан шинжилгээ, нэгтгэн холбох, нотолгоот дүгнэлт хийх, танин мэдэхүйн анализ, синтез, индукц, дедукци, лабораторийн туршилт, загварчлалын арга, түгээмэл аргаас харьцуулан жиших, тусгай аргаас байгалийн шинжлэх ухааны материал судлалын аргыг, соёл судлалын шинжлэх ухааны музей судлалын материал тодорхойлох аргуудыг хослуулсан.

Музейн нэхмэл эд өлгийн зүйлийн онцлог, Музейн нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтын өнөөгийн байдал, Монголын музейн нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтыг сайжруулах арга зам гэсэн үндсэн гурван бүлэгтэй, нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтыг сайжруулах арга зүйн зөвлөмж, МҮМ-н сан хөмрөг 10,1,7 болон үзүүлэгийн танхим 3,7,8-н дулааны хэм, харьцангуй чийгшил, гадна агаарын дулааны хэм, харьцангуй чийгшлийн үзүүлэлт, тойм статистик сараар, гадна дулааны хэм болон дотор дулааны хэмийн регрессийн шинжилгээний үр дүн, регрессийн шулуун болон түүврийн бодит утга, үзүүлэгийн танхим №3 болон гадна дулааны хэм-тохирох утга, үзүүлэгийн танхим №10 болон гадна дулааны хэм-тохирох утга, шалгалтын гэрчилгээ, шалгалтын дүн зэрэг хавсралт, дүгнэлт (хуудас 121-124), номзүй (125-131), нийт 158 хуудастай.

Музейн нэхмэл эд өлгийн зүйлийн онцлог судалгааны нэгдүгээр бүлэгтээ нэхмэл эд өлгийн зүйлийн төрөл, нэхмэл эд өлгийн зүйлийн физик, химийн шинж чанар хоёр зүйлдээ, цаашдын хадгалалтын арга зүйг боловсруулах, техник хэрэгсэл, өрөө, тавиурыг тооцох, хадгалалтын шаардлага, нэхмэлийг хадгалах нөөц бололцоог тооцоолох, нэгж үзмэрийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах ач холбогдлыг, Монголын үндэсний музейн сан хөмрөгийн эд өлгийн материалын төрөл, гарал, физик шинж чанарыг тодорхойлсон. Музейн нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтын өнөөгийн байдал дараагийн бүлэгтээ нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтад нөлөөлж буй хүчин зүйл, нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтын орчны стандартын хэрэгжилт хоёр зүйлээр музейн үзмэр, эд зүйлийн эрсдэлийг бууруулахын тулд төсөв санхүү, сан хөмрөг, үзүүлэгийн танхимын зай талбай хүрэлцээ, стандартын шаардлага хангасан музейн барилга, зориулалтын техник хэрэгсэл тоног төхөөрөмжийг хангамж, сан хөмрөгт сөрөг нөлөөтэй арван хүчин зүйлс, эрсдэлийн үнэлгээний үр дүнг дүгнэсэн. Монголын музейн нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтыг сайжруулах арга зам сүүлийн бүлэгтээ Сан хөмрөг дэх нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтын нөхцөл байдалд хийсэн шинжилгээ, Сан хөмрөг дэх нэхмэл эд өлгийн зүйлийн материалын шинж чанарын шинжилгээ, Нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтыг сайжруулах боломж гурван зүйлээр нөхцөл байдал, чанарын шинжилгээ, хадгалалтыг сайжруулах арга замуудыг тодорхойлсон. Музейн нэхмэл зүйл, хадгалалт, шинж чанар, Монголын үндэсний музейн сан хөмрөгийн уг материалын бүтэц, төрөл, гарал, физик шинж чанар, хадгалалтын стандартаар эрсдэл бууруулах, үнэлгээний үр дүн, эд өлгийн төрөлжүүлэл, статистик боловсруулалт, гэрлийн микроскопын шинжилгээний арга зүй зэргийг тодруулсан. Дүгнэлтэд гурван бүлгийг найман зүйлээр дүгнэж, нэхмэл эд өлгийн төрөлжүүлэл, нэхмэлийн бүтэц, гарал үүсэл, онцлог, физик, химийн шинж чанар тодруулалт, эрсдэлийн үнэлгээ, хадгалалтын дотор орчны дулаан, чийгшлийн хамаарлын 3 жилийн хэмжилтээр статистик боловсруулалт, нэхмэлийг гэрлийн микроскопын шинжилгээ музейд нэвтрүүлэх, хадгалалтын

арга зүйг тодруулсан.

Жамбалдоржийн Мяндас. Монгол Улсын аймгийн музейн сан хөмрөгийн бүрэлдэхүүний шинжилгээ (2019) бүтээлээр Соёл урлагийн их сургуульд соёл судлалын ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон. Эрдэм шинжилгээний удирдагчаар доктор (Sc.D), профессор С.Батсуурь, доктор (Ph.D), профессор Д.Мандах нар ажиллажээ. Нэр томьёоны тайлбар, удиртгал, үндсэн гурван бүлэг, 12 дэд бүлэг, дүгнэлт, ном зүй (125-131), хавсралт (56), нийт 164 хуудастай. Монгол Улсын 21 аймгийн музейн сан хөмрөг дэх цуглуулгын ангиллын төрөл, хоорондын харьцаа, соёлын өвийн бүртгэн баримтжуулалт, үнэ цэнжүүлэлт, иж байдлын төвшинд судалгаа хийх судалгааны зорилготой. Шинжлэх ухааны судалгаанд хэрэглэгддэг тоон шинжилгээний аргууд, харьцуулалт, зэрэгцүүлэл, загварчлал, музей судлалд баримталдаг тезаврын онол арга зүйтэй.

Монгол Улсын аймгийн музейн сан хөмрөг, бүрэлдэхүүн нэгдүгээр бүлэг нь Монгол Улсын аймгийн музейн үүслийн түүхэн товчоон, Музейн сан хөмрөгийн ангилал, олон улсын жишиг, Музейн сан хөмрөгийн ангилал, харьцуулсан шинжилгээ; Монгол Улсын аймгийн музейн сан хөмрөг дэх археологийн болон угсаатны соёлын өвийн бүрэлдэхүүн хоёрдугаар бүлэгт Музейн сан хөмрөг дэх археологийн соёлын өвийн сан хөмрөгийн бүрэлдэхүүн, Монголчуудын гэр сууц, дотоод тавилга, гэр зуурын эд өлгийн зүйлийн бүрэлдэхүүн, Дээл хувцас, гоёл чимэглэл, эдлэл зүүсгэл, түүнд холбогдох эд өлгийн зүйлийн бүрэлдэхүүн, Монголчуудын эрхлэх аж ахуйн холбогдох эд өлгийн зүйлийн бүрэлдэхүүн; Монгол Улсын аймгийн музейн сан хөмрөг дэх оюуны соёлын өвийн бүрэлдэхүүн гуравдугаар бүлэгт Ардын гар урлалын соёлд холбогдох эд өлгийн зүйлийн бүрэлдэхүүн, Тоглоом наадгай, түүнд холбогдох эд өлгийн зүйлийн бүрэлдэхүүн, Шашин шүтлэг, түүнд холбогдох эд өлгийн зүйлийн бүрэлдэхүүн, Уламжлалт бичиг үсгийн соёлд холбогдох эд өлгийн зүйлийн бүрэлдэхүүн, Уламжлалт хөгжмийн зэмсэг түүнд холбогдох эд өлгийн зүйлийн бүрэлдэхүүн зүйлүүдтэй.

Аймгийн музейн сан хөмрөгийн төрөлжүүлэл (түүхийн, шашин шүтлэгийн, угсаатны, археологийн, урлаг, байгалийн) цогц харьцаа, цуглуулгын өнөөгийн бодлогод үнэлгээний судалгаа хийсэн. Аймгийн музейн сан хөмрөгт байгаа археологийн соёлын өвийн эд өлгийн төрөл нь цогц бус олон янзын салангид зүйлсээс бүрдэж байгаа нь түүх, археологийн судалгаа, үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулалт, социализмын үеийн үзэл суртал, хүн ардын оюун санаа хаагдмал байсантай холбоотой байна. “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу нутгийн уугуул ард түмний биет болон биет бус соёлын өвийг цогц баяжуулах, түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын мэдээллийг сансрын зураг, дижитал технологийн зураглалаар баяжуулах, музей судлалын зарим нэр томьёог оновчтой цэгцэлж, цаашид музейн ажлын арга зүйд нэвтрүүлэх, сан хөмрөгийн эд өлгийн бүрэлдэхүүнийг системтэй ангилал, двюгийн аравтын ангиллыг ашиглах шаардлагатай. Аймгийн музейн сан хөмрөг цуглуулгад түүхийн холбогдолтой 7.13%-51,9%; шашин шүтлэгийн холбогдолтой 4,9%-56,6%; угсаатны зүйн 15,0%-46,9%; археологийн 60,3%-25,7%; урлаг уран сайхны 2,5%-17,2%; байгалийн 3.0%-27,4% -ийг тус тус эзэлж, энэ зургаан төрлийн цуглуулгын харьцаа алдагдсан

байна. Музей цуглуулгын судалгааны үе шат алдагдаж, эд өлгийн зүйлийн мэдээлэл агуулагч хамгийн чухал анхдагч баримтын талаарх эрдэм шинжилгээний тодорхойлолт туйлын дутуу байгаа нь судалгаагаар батлагдлаа гэж дүгнэсэн.

Ерөнхий дүгнэлтэд, XX зууны эхэн үеэс музей, хүрээлэн, их сургууль, удирдах газар зэрэг нь музейн хадгалалт, хамгаалалт, материал судлалын судалгаа, танин мэдэхүй, аргагүй, шинжлэх ухааны нээлтийг судлан хөгжүүлэх музей судлалын эрдэм шинжилгээний үүрэг хариуцлага хүлээж, сэтгүүл, бүтээл, товхимол эрхлэн ажиллаж байна. 1950-д оны үеийн тус сэтгүүлүүдийн нэгэн дугаарт ШУА-ийн эрдэм шинжилгээний ажилтан О.Намнандорж Музей ба Нийгэмлэг (2016, 7-8) эрдэм шинжилгээний өгүүлэлдээ тухайн үеийн Улсын төв музей, Хувьсгалын музей, Сүхбаатарын музейн барилга, үзэгчид, тав тух, сан хөмрөг, цуглуулга, хадгалалт хамгаалалт, нийгмийн өөрчлөлт музейд хэрхэн нөлөөлж болох талаар музей ба нийгмийн харилцааг гярхай харж, тодорхой бичсэн байдаг.

Хэлэлцүүлэг

А.Янжив (2014), Д.Мөнхтоого (2019), Ж.Мяндас (2019) нар сан хөмрөг (хадгалалт)-ийн (Mensch 1989) судалгааны үр дүнд гарсан сан хөмрөгийн зай талбайн хуваарилалт, бодлого, үнэлгээ, орчны нөлөөллийн шинжилгээ, актлах, бусдад шилжүүлэх нэр томъёоны оноолт, горимууд, цогц харьцаа, төрөлжүүлэл, нэхмэлийн бүтэц, гарал үүсэл, онцлог, физик, химийн шинж чанар тодруулалт, эрсдэлийн үнэлгээ, орчны дулаан, чийгшлийн хамаарлын статистик боловсруулалт, гэрлийн микроскопын шинжилгээ, арга зүй, түүхийн, шашин шүтлэгийн, угсаатны, археологийн, урлаг, байгалийн төрлийн цуглуулгын харьцаа нь хэрэглээний музей судлал (Razgon 1978), (Sofka 1980), (Teather 1983), (Stransky, Mensch 1989), (Maroević 1998), тезаврын сан хөмрөгийн үнэт чанар, ач холбогдлыг нээн илрүүлэх, хадгалалт хамгаалалтыг хангах онол (Stransky 1984), (Mensch 1992, 176)-ын судалгааг хийсэн байдаг. Салли Ваттерсоны (2014) нийгэм түүхийн агуулгатай музей, үзэсгэлэнгийн үзмэр, эдийн соёл, улс төрийн үзэл санаа, социализм, ардчиллын тухай өгүүлэмж, төлөөлөл, тайллын судалгаа нь нийгмийн музей судлал (Sochira 1980), (Stransky, Mensch 1989) тус бүр болж манай улс дахь музей судлалын өнөөгийн хөгжил дэвшил болж байна. 2023 оны 1-р сарын 18-нд, судлаачид ИКОМ-ын Пакистан улсын музейн үндэсний хорооны зохион байгуулдаг *International Virtual Conference on Museums, 2022-2023*-д Монголын музей судлалын судалгаа (*Study of Mongolian Museology*) сэдвийн дор судалгааны үр дүнгээ олон улсад танилцуулж, дуу хоолойгоо хүргэсэн. Эрдэм шинжилгээний хуралд Хорват улсын Загребын их сургуулийн профессор Дарко Бабики, ОУ-ын бүс нутгийн музейн хороо (*International Committee of Regional Museum, ICOM-IRC*)-ны дарга Захида болон Монгол, Энэтхэг, АНУ, Пакистан, ОХУ-ын музей судлаачид оролцож сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн байдаг.

Дүгнэлт

Судлаачдын судалгааны үр дүн музейн ажлын талбарт буусан эсэх нь өнөөгийн бидний анхаарал татсан асуудал болох бөгөөд монгол судлаачдын сан хөмрөгийн судалгааны үр дүн стандартчлагдаагүй, ялангуяа Салли Ваттерсоны судалгааны диссертац өнөөг хүртэл бидний төрөлх хэлээр шинжилгээ, ажил хэрэг инновац болж практикт буугаагүй байгаа нь өмнө нь өгүүлсэн өнөө л музейн өдөр тутмын нүсэр ажлаас үл хэтрэх завгүй, эсхүл үл тоомсорлол, эсхүл хэлний бэрхшээлтэй холбоотой болж байна. Үүнээс гадна бид Глузинскийн (1983) музей судлалыг хөгжүүлснээр музейн сургалтыг баяжуулна, үр дүн нь музейд тусгал болж практикт буудаг буюу музей судлал-музейн сургалт-музей хэмээсэн гурвал мөчлөгт давтагдах шинж чанартай загварыг санахдаа ямагт музей судлалын байгууллага, музей судлаачдыг дэмжин хөгжүүлж байх нь зүйтэй болж байна.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Бумаа, Д. 2009. “Музей судлал шинжлэх ухааны тухай.” *Нүүдэлчдийн өв судлал IX*.

Бумаа, Д., Буянжаргал, 2018. “Музей судлал ба Нүүдэлчдийн өв судлал сэтгүүлд хэвлэгдсэн музей судлалын өгүүллийн жагсаалт.” *Studia Museologica XIX-I*.

Мөнхтоогоо, Д. 2019. “Монголын музейн нэхмэл эд өлгийн зүйлийн хадгалалтыг сайжруулах судалгаа, боловсруулалт (Монголын үндэсний музейн жишээн дээр).” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Мяндас, Ж. 2019. “Монгол орон нутгийн музейн сан хөмрөгийн шинжилгээ.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Намнандорж, О. 2016. “Музей ба Нийгэмлэг.” *Музей судлал сэтгүүл XVII*.

Оюунхишиг, Ц. 2012. “Музей судлал, Нүүдэлчдийн өв судлал эрдэм шинжилгээний сэтгүүлийн тойм.” *Нүүдэлчдийн өв судлал 12: 272-275*.

Янжив, А. 2014. “Монгол улсын музейн цуглуулгын хадгалалтын зохистой орчныг бүрдүүлэх арга зам.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Гадаад хэлээр:

Dolák, Jan. 2022. *Museology and its theory, Technické muzeum v Brně*.

Maroevic, Ivo. 1998. *Introduction to Museology - The European Approach*, Gary Edson, ed. English Edition. Munich: Verlag Dr. Christian Muller-Straten.

Mensch, P. Van. 1992. “Toward a Methodology of Museology.” Doctor’s Thesis, University of Zagreb.

Sally, Watterson. 2014. “Jinjin Mongol/True Mongolian - Museums of Mongolia negotiating the twentieth century.” Doctor’s Thesis, University of Deakin, Australia.

Sofka, Venos. 1980. *Museology is the study of the museum and its activities, Museological Working Papers – MuWoP (1)*, ed. Sofka, Venos. Stockholm.

Teather, Lynne. 1983. “Museology and its Traditions: The British Experience, 1948-1945.” Ph.D Thesis, University of Leicester, Leicester.

Tsuruta Soichiro. 1980. *Museology is the study of the museum and its activities, Museological Working Papers – MuWoP (1)*, ed. Sofka, Venos. Stockholm.